



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 317 дугаар тогтоол, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудыг нийлүүлэн, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар болгож өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийг нийлүүлэн зохион байгуулах, бүтэц, орон тоог холбогдох хууль тогтоомж, дүрэмд нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Нийлүүлэн зохион байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, ажлын явцыг тухай бүр танилцуулж, нэгдсэн тайлан гаргахыг Ажлын хэсэг (Б.Уянга)-т үүрэг болгосугай.


ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013336


Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын даргын 2022
оны 10 дугаар сарын 25-ны өдрийн
А/66 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч	Б.Уянга	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга
Гишүүд:	С.Шинэ-Од	Үндэсний геологийн албаны Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	Ц.Шинэхүү	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга
	Д.Дариймаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Сүнжидмаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	С.Пүрэвгарьд	“Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч
	Б.Содовжамц	“Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Х.Санчигдорж	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын ахлах шинжээч /зөвшилцсөнөөр/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 10 дугаар
сарын 20-ны өдрийн 4/66 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 317 дугаар тогтоолын дагуу “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудыг нийлүүлэн, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар болгож өөрчлөн зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

1. “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийх, хаалтын баланс тус тус гаргах;
2. Өр авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулах;
3. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газрын эхлэлтийн балансыг гаргах;
4. “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудын баримт бичгийг Үндэсний архивт шилжүүлэх;
5. “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газруудын захирал болон ажилчдыг чөлөөлөх;
6. “Геологийн судалгаа-шинжилгээний төв”-ийн удирдлагыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний геологийн албаны саналыг авч томилох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх;
7. Үндэсний геологийн албаны саналыг авч “Геологийн судалгаа-шинжилгээний төв”-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх.